Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
# 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

*Тайланг хянасан:* *Төсвийн Төвлөрүүлэн захирагч*

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА ........................................................Б.БАТЖАРГАЛ

*(гарын үсэг)*

(Гарын үсэг)

.....................

*(Огноо)*

*Тайлан гаргасан:* *Төсвийн шууд захирагч*

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ .............................................. С.ОТГОНБААТАР

(Гарын үсэг)

.....................

*(Огноо)*

# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
# 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Стратегийн төлөвлөгөөний зорилго 1: Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, ажил олгогч, даатгуулагчтай хамтран ажиллах;*** | | | | | | | |
| ***Зорилт 1:*** *"Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, иргэдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан (актуар) тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 1.1. | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/ болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах; | - | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | 9 | Тухай бүр | Дээд газраас 2026 оны эхний хагас жилийн байдлаар Тушаал 1, Зөвлөмж 4, Чиглэл 1, Албан даалгавар 1, нийт 7 баримт бичгийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан байцаагч нарт тухай бүр танилцуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31 өдрийн 242 дугаар тогтоол "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай"-ын дагуу нийт 25044 тэтгэвэр авагчийн тэтгэвэрт өөрчлөлтийг хийж тэтгэвэр тогтоолын хуудсанд бичилтийг баталгаажуулан ажилласан.<br>2026 оны жилийн эцсийн байдлаар давхацсан тоогоор сар бүр 26659 иргэний тэтгэврийг хуулийн хугацаанд нь олгож ажилласан. Эхний хагас жилийн байдлаар шинээр өндөр насны тэтгэвэр 406, Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр 121, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 26, ҮОМШӨ Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр 3, Цэргийн алба хаасны тэтгэвэр 15, Цэргийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр 3, Тэтгэврийн тусгай зохицуулалт 65 нийт 639 иргэнд шинээр тэтгэвэр тогтоосон. Үүнээс 1-8 хорооны өндөр насны тэтгэвэр 136, Тэжээгчээ алдсаны тэтгэвэр 11, Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр 41, Тэтгэврийн тусгай зохицуулалт 18 нийт 218 иргэний материалыг журмын дагуу цахим болон цаасан хэлбэрээр хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 5880, ажилгүйдлийн тэтгэмж 694, жирэмсэн болон амаржсаны тэтгэмж 767, Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж 282, ҮОМШӨ-ний Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 89, ҮОМШӨ, сэргээн засах сувиллын зардал 19, нийт 7731 даатгуулагчид тэтгэмжийг бодож олгосон. Үүнээс 7611 даатгуулагчийн тэтгэмж авах хүсэлтийг цахимаар хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэж тэтгэмжийг хяналт тавин шилжүүлэн ажилласан | *100%* |
| 1.2. | Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль, | 1,050,5 сая.төг | Санхүүгийн тайлан аудитаар батлагдсан. | 738314,3<br><br>265539,8 | 326090,3<br><br>326090,3 | НДЕГазрын даргын тушаалаар баталсан үйл ажиллагааны урсгал зардлын 2026 оны эхний хагас жилийн төсөв 1,050.5 сая төгрөгийг сар бүр зориулалт, хөтөлбөр арга хэмжээний дагуу зарцуулан ажиллах зорилт тавин ажиллаж, нийт 1,038.1 сая төгрөгийг үйл ажиллагааны урсгал зардалд зарцуулж 12.4 | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах; | | | | | сая төгрөгийн төсвийн хэмнэлт гаргаж, төрийн хэмнэлтийн хууль, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэл, батлагдсан төсвийг хэрэгжүүлэн ажилласан. | |
| 1.3. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын биелэлтийг хангах; | - | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нийгмийн даатгалын сангаас олгох ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, газрын даргын баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу ажил олгогч, даатгуулагчдад сургалт, зөвлөгөө мэдээллийг хүргэн ажиллаж байна.<br>Эхний хагас жилийн байдлаар нийт 25 ажил олгогчийн 300 гаруй даатгуулагчдыг сургалтад хамруулсан байна. | 100% |
| 1.4 | “Нийгмийн даатгалын хамралтын 2026 оны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | | Албан журмын даатгуулагчдын тоо, хувь | 124,486<br>94,2% | 126,786<br>100% | 2026 оны 02 дугаар улирлын байдлаар нийгмийн даатгалд хамрагдаагүй 5159,3 сая төгрөгийн цалингийн сан бүхий 252 аж ахуйн нэгж байгууллагын албан хүсэлтийг хүлээн авч, нийгмийн даатгалын программд шинээр бүртгэж, мэдээллийг бүрэн оруулж, орлогын байцаагчид хуваарилан ажиллалаа. Албан журмын даатгалд 315 даатгуулагчийг шинээр хамруулсан.<br>2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт Сикос программ дээр 5240 хүн сайн дурын даатгуулагч хамрагдсан байна. Үүнээс энгийн 4115 даатгуулагч хамрагдсан. Цахимаар энгийн даатгуулагч-504 гэрээ шинээр хийсэн.<br>Сайн дурын даатгалын хөгжлийн бэрхшээлтэй 0-18 насны хүүхдээ асарч байгаа эцэг эх нийт 135 хамрагдсанаас шинээр нэмэгдсэн 53 байна.<br>Сайн дурын даатгуулагч 0-3 хүртэлх насны хүүхэдтэй эх 393 даатгуулагч шимтгэл төлдгөөс шинээр 85 эх хамрагдсан байна. Сайн дурын даатгалд хамрагдсан малчин 16 хамрагдсан. | 100% |
| | | | Сайн дурын даатгалд хамрагсадын тоо, хувь | 5,920<br>82,9% | 7,143<br>100% | | |
| | | | Малчдын хамралтын тоо, хувь | 12<br>100% | 12<br>100% | | |
| 1.5 | Ажил олгогч, иргэд, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, үр дүнг хагас жил тутам Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх; | - | 2 удаагийн сэтгэл ханамжийн судалгаа хийгдсэн байна. | 100% | 100% | Иргэд, даатгуулагч ажил олгогчдод нийгмийн даатгалын ажил үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, даатгуулагчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилгоор сэтгэл ханамжийн судалгааг жилд 2 удаа авч нэгтгэн дүгнэж, үр дүн дээд газарт тайлагнаж, цаашид сайжруулах шаардлагатай асуудлын талаар зөвлөгөө мэдээллийг авч өдөр тутмын үйл ажиллагаанд сайжруулалт хийх, байцаагч албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. | *100%* |
| ***Стратегийн төлөвлөгөөний зорилго 2: Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэн сангийн орлогыг бүрдүүлэн нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тогтвортой, бие даасан найдвартай байдлыг хангах замаар сангийн зарлагын гүйцэтгэлийг хангах, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал, хөнгөлөлт,*** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, хяналт шалгалт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах*** | | | | | | | |
| ***Зорилт 2:*** *“Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт, шимтгэлийн хөнгөлөлт,чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, өр барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, мөнгөжүүлсэн орлогыг тэтгэврийн нөөц санд байршуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 2.1. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах. | | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ. | 100% | 100% | 2026 оны эхний хагас жилийн байдлаар Нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн орлогын Төрийн сан, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банк, Капитрон банк, Голомт банк, Хаан банкны дансанд орж ирсэн шимтгэлийн орлого 460,670.9 сая төгрөгийг НДЕГ-ын төвлөрсөн санд цаг тухай бүрт нь бүрэн төвлөрүүлсэн. | *100%* |
| 2.2. | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах. | | Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно. | 100% | 100% | НДСангийн төсвийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, төсвийн хуваарийн дагуу гүйцэтгэлийг хангаж ажиллаа. Тэтгэврийн даатгалын сангийн зарлага 148,797.8 сая төгрөг батлагдсанаас 147,814.5 сая төгрөг, Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 9,327.3 сая төгрөг батлагдсанаас 9,320.1 сая төгрөг, ҮОМШӨ сангийн зардал 898.7 сая төгрөг батлагдсанаас 931.1 сая төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 6,209.4 сая төгрөг батлагдсанаас 6,211.6 сая төгрөг зарцуулж нийт 955.9 сая төгрөг хэмнэгдэж Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн батлагдсан хуваарийн дагуу зардлыг зүйл зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна. Нийгмийн даатгалын сангийн батлагдсан төсөв гүйцэтгэлээр 955.9 сая төгрөгөөр хэмнэлттэй гарсан.<br>Нийгмийн даатгалын сан хариуцах шимтгэлийг улирал бүр гүйцэтгэлээр бүрэн шилжүүлж ажилласан | *100%* |
| 2.3. | Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах. | | Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана. | 100% | 100% | Үйл ажиллагааны зардалд батлагдсан 2026 оны эхний хагас жилийн төсөв 1,050.5 сая төгрөгийг сар бүр зориулалт, хөтөлбөр арга хэмжээний дагуу зарцуулан ажиллах зорилт тавин ажиллаж, хэмнэлтийн горимоор батлагдсан төсвийг хэтрүүлэлгүй зарцуулж, төсвийн хэмнэлт гаргаж ажилласан. Ажиллагсадтай холбоотой өглөг, авлага үүсгэлгүй ажиллаж, бусад өглөг авлагыг бууруулсан болно. Батлагдсан төсвийн гүйцэтгэл 1,038.1 сая төгрөг буюу 12.4 сая төгрөгийн хэмнэлт гарган ажилласан. | *100%* |
| 2.4. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн | | | | | Нийгмийн даатгалын сангуудын тайлан гаргах, бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор тухайн ажил хариуцсан байцаагч, сан хариуцсан мэргэжилтэн нартай хамтран тооцоо нийлэх, тайлан гаргах хугацааг тусгаж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах | | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | 100% | 100% | тайлангийн хуваарь гарган, хуваарийн дагуу ажилладаг.<br>Сангийн санхүүгийн тайланг чанартай, цаг хугацаанд нь үнэн зөв гаргахад анхаарч ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон 2026 оны 1-р улирлын санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн. Сар бүрийн 2-ны дотор сангийн болон байгууллагын санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, сангийн авлага өглөгийн мэдээ, харилцах дансны үлдэгдлийн мэдээ, тэтгэвэр тэтгэмж авагчдын тооны мэдээ, харилцах дансны нэгдсэн товчооны мэдээ зэрэг 8-н төрлийн мэдээг бэлтгэн гаргаж НДЕГазарт болон Статистикийн байгууллагад хүргүүлэн ажилласан.<br>Байгууллагын үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлийн 2026 оны 03 дугаар сарын мэдээг тогтоосон хугацаанд дээд газарт хүргүүлээгүй, хугацаа хоцроосон зөрчил гаргасан үйл ажиллагааны нягтлан бодогчид сануулан, цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байхаар анхааруулан ажиллаж байна. | 95% |
| 2.5. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах. | | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийг захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана. | 100% | 100% | Үндсэн хөрөнгийн болон эд хөрөнгийн хагас, бүтэн жилийн дотоод тооллого хийх ажлыг газрын даргын баталсан бүрэлдэхүүнээр хийж тайланг удирдлагад танилцуулж, тайлан мэдээг дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллаа.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ирүүлсэн 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А-1/425 тоот “Шинэ систем нэвтрүүлэх зөвлөмж, албан даалгавар”-өөр өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн шинэ системийг нэвтрүүлсэн мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 730 тоот тогтоол, НДЕГазрын даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/392 тушаалыг хэрэгжүүлэн үндсэн хөрөнгийг данснаас хасах, актлах ажлыг хийж хэрэгжүүлсэн. | *100%* |
| 2.6. | Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлттэй ажиллах. | | Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ. | 100% | 100% | Нийгмийн даатгалын сангийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд “Баталгаат тооцоолол Аудит” ХХК аудит хийсэн. Тус аудитын байгууллагад шаардлагатай тоон мэдээлэл, судалгаа, байгууллагын үйл ажиллагаа, удирдлага хяналтын системийн талаарх мэдээллүүдийг хүргүүлэн ажиллаж Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийн тайланд “**ӨӨРЧЛӨЛТГҮЙ**” дүгнэлт авсан.<br>Санхүүгийн тайлангийн аудитаар үйл ажиллагааны зардлын төсвийн гүйцэтгэлд өгсөн нийт 78.7 сая төгрөгийн дүн бүхий 7 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг тайлагнасан. Нийгмийн даатгалын сангийн төвсийн гүйцэтгэлд өгсөн нийт 76.2 сая төгрөгийн 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн. Зөвлөмжийн дагуу хийх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж гүйцэтгэлийг аудитын байгууллагад хүргүүлэн ажиллаа. Мөн зөвлөмжийн биелэлтийг гаргаж НДЕГазрын ДАМГазарт хүргүүлсэн. | *100%* |
| 2.7. | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх. | | Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн, | 100% | 100% | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 06/68 тоот албан бичгээр ирүүлсэн “Арилжааны банктай байгуулсан гэрээ дүгнэх, гэрээнд өөрчлөлт оруулах санал авах тухай” албан бичгийн дагуу харилцагч арилжааны 5 банктай байгуулсан гэрээний зүйл заалтын хэрэгжилтийг заалт нэг бүрээр дүгнэж, дүнг тогтоосон хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн. | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжилтийг дүгнэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ. | | | | |
| 2.8. | Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх. | | Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ. | 100% | 100% | Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлогыг бүртгэх, тэтгэвэр тэтгэмжийн олголтын файл, жагсаалт үүсгэх тухай бүртээ цахим мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлэн, хяналт тавьж ажиллаж байна. Ташаарсан болон алдаатай гүйлгээг бусад авлага, өглөгийн дансанд бүртгэж, залруулга хийн ажиллаж байна. Мэдээллийн бааз, тайлангийн хаалтыг цаг тухай бүрт нь хийлгэсэн. | *100%* |
| 2.9. | Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх" төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх. | | Тухай бүр | 100% | 100% | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг "Core" системээр хөтлөн, санхүүгийн тайлан мэдээг гарган ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд НДЕГ-ын СБГ-ын зохион байгуулж буй ZOOM уулзалт, танхимын сургалтад тухай бүр хамрагдаж, өгсөн үүрэг чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын сангуудын анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг шинэ системээр гарган ажиллаж байна. | *100%* |
| 2.10. | Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах | | Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | 100% . | 100% | Сангийн болон үйл ажиллагааны тайлангаар гарсан өглөг авлагыг улирал бүр тооцоо нийлсэн актаар баталгаажуулан тайлангийн хаалтыг тухай бүрд нь хийж байна. | *100%* |
| ***Зорилт 2.1:*** "*Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, сан бүрдүүлэх, ажил олгогч, даатгуулагч, сайн дураар даатгуулагчдыг ниймгийн даатгалд хамруулах, шимтгэлийн өр барагдуулах ажлыг зохион байгуулах ажлыг зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нийгмийн даатгалын байгууллагуудыг мэргэжил, арга зүгээр хангах*" ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 2.1.1 . | Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт | | Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь | 97.6% | 100% | 2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт Сикос программ дээр 5240 хүн сайн дурын даатгуулагч хамрагдсан байна. Үүнээс энгийн 4115 даатгуулагч хамрагдсан. Цахимаар энгийн даатгуулагч-504 гэрээ шинээр хийсэн.<br>Сайн дурын даатгалын хөгжлийн бэрхшээлтэй 0-18 насны хүүхдээ асарч байгаа эцэг эх нийт 135 хамрагдсанаас шинээр нэмэгдсэн 53 байна.<br>Сайн дурын даатгуулагч 0-3 хүртэлх насны хүүхэдтэй эх 393 даатгуулагч шимтгэл төлдгөөс шинээр 85 эх хамрагдсан байна. Сайн дурын даатгалд хамрагдсан малчин 16 хамрагдсан. | *80%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тавьж ажиллах; | | | | | | |
| 2.1.2. | Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах; | | Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь | 80% | 100% | 2026 оны 02 дугаар улирлын байдлаар нийгмийн даатгалд хамрагдаагүй **5159,3** сая төгрөгийн цалингийн сан бүхий **252** аж ахуйн нэгж байгууллагын албан хүсэлтийг хүлээн авч, нийгмийн даатгалын программд шинээр бүртгэж, мэдээллийг бүрэн оруулж, орлогын байцаагчид хуваарилан ажиллалаа. Албан журмын даатгалд **315** даатгуулагчийг шинээр хамруулсан. | *100%* |
| 2.1.3. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний үлдэгдэлээс 15-аас доошгүй хувиар бууруулах; | | Ажил олгогчоос төлөх шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 15-аас доошгүй хувиар бууруулна. | 80% | 100% | Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулах чиглэлээр 2026 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хамралт, орлогын хэлтсийн байцаагчдад танилцуулан Газрын даргын 2026 оны 05 дүгээр сарын 13-ны өдөр баталсан шимтгэлийн авлага барагдуулах, орлогын төлөвлөгөө биелүүлэх чиглэлээр 2026 онд хийж гүйцэтгэх хэлтсийн ажлын төлөвлөгөөг батлуулан өр авлага барагдуулах ажлын төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. 2026 оны эхний хагас жилд нийт 67207,8 сая төгрөгийн шимтгэлийн авлагын 65314,6 сая төгрөг буюу 97% ХХК, гадаадын хөрөнгө оруулалт ХХК, бусад, 1893,2 сая төгрөг 2,8% төсөвт байгууллага болон улсын төсөвт байгууллагууд эзэлж байна.<br>2026 оны 2 дугаар улирлын байдлаар нийгмийн даатгалын санд **394478,8** сая төгрөгийн орлого төвлөрүүлж, **67207,8** сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагатай гарсан бөгөөд орлогод эзлэх авлагын хэмжээ **17** хувь байна.<br>2026 оны оны эхний авлага 74675,4 сая төгрөгөөс 2 дугаар улирлын байдлаар 67207,8 сая төгрөг болж 10 хувиар буурсан үзүүлэлттэй байна.<br>Насжилт өндөртэй 1270 ажил олгогчийн 11.2 тэрбум төгрөгийн өрийг шат дараалсан арга хэмжээ авсан байдлаар ангилж судалгаа гарган ажиллаж цаашид хийх ажлын талаар зөвлөмж өгч ажиллалаа. Мөн хуримтлагдсан өндөр өртэй ААН-тэй уулзалт хийв. Үүнээс 54 ажил олгогчийн 267.7 сая төгрөг барагдуулсан.<br>***Албан шаардлага:*** Тайлант хугацаанд 3679,2 сая төгрөгийн өртэй 25 ажил олгогчдод шимтгэлийн авлага барагдуулах албан шаардлага хүргүүлсэн. Үүнээс 4 ажил олгогчийн 18,1 сая төгрөгийн авлага бүрэн барагдсан.<br>***Гэрээ:*** Тайлант хугацаанд 9998,0 сая төгрөгийн өртэй 61 ажил олгогчтой шимтгэлийн авлага барагдуулахаар уулзалт хийж, гэрээ байгуулан 2911,5 сая төгрөгийн авлагыг барагдуулсан байна.<br>Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй хуримтлагдсан авлагын **21,1** тэрбум төгрөг буюу **48%** хувийг худалдаа үйлчилгээ, барилга, зам тээвэр, уул уурхайн салбарууд эзэлж байна. Зам, барилгын салбар нь улсаас тендер авч урьдчилсан гүйцэтгэлийн санхүүжилтийг тухайн ажил олгогч хариуцаж гүйцэтгэдэг ба барилга болон замын гүйцэтгэл бүрэн дууссаны дараа улсын төсвөөс санхүүжилтээ авдаг. Төслийн хугацаанд бараа материал, тээврийн үнэ огцом нэмэгдэж дээрх салбарууд алдагдал хүлээж, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаандаа төлж чадахгүй өр хуримтлагдаж байна. Газрын үйл | *82,5 %* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагаанаас үл хамаарч нийгэм, эдийн засгийн хямрал нөлөөлж иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд шимтгэлээ төлөхгүй удаашралтай байна.<br>***Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн:*** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн тус газраас нэхэмжлэлтэй 7462,0 сая төгрөгийн өртэй 59 ажил олгогчийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд байна. Үүнээс 371,0 сая төгрөгийн авлагатай 4 ажил олгогчийн авлага бүрэн барагдсан. 460.7 сая төгрөгийн өртэй 7 ажил олгогчийн гүйцэтгэх ажиллагааг ШШГтх-н 27.2.6-т зааснаар төлбөр төлөгч иргэн, эсхүл төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, төлөөлөгч, тэдгээрийн эд хөрөнгийг эрэн сурвалжилж, олж тогтоох хүртэл хугацаагаар түдгэлзүүлсэн байна.<br>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 46 аж ахуйн нэгж байгууллагын **5278.1 сая** төгрөгийн өр барагдуулах явцыг эрчимжүүлэх зорилгоор өр барагдуулалтын судалгаа гаргаж, шийдвэр гүйцэтгэгч болон байцаагч нарт бодит мэдээллээр хангаж ажиллаж байна. 2026 оны 02 дугаар улирлын байдлаар **88.2** сая төгрөгийн өртэй 1 аж ахуйн байгууллагын авлага бүрэн барагдсан. | |
| 2.1.4. | Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулсан байх; | | Ажил олгогчоос төлөх шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30-аас доошгүй хувиар бууруулна. | 80% | 100% | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах, орлогын төлөвлөгөө биелүүлэх чиглэлээр 2025 онд хийж гүйцэтгэх хэлтсийн ажлын төлөвлөгөөг батлуулан өр авлага барагдуулах ажлын хүрээнд **1,769.06** сая төгрөгийн авлагыг барагдуулж удирдлага нягтлан бодогчдод урсгал авлага үүсгэхгүй байхад анхааруулж ажиллаа.<br>Тус газарт бүртгэлтэй нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн удирдлагад албан шаардлага хүргүүлэн өрийг 2026 ондоо багтаан төлөхийг мэдэгдсэн. Нийт авлагаас 1893,2 сая төгрөг буюу 2,8% төсөвт байгууллага болон улсын төсөвт байгууллагууд ээзлж байна. | 90% |
| 2.1.5. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх ажил зохион байгуулах; | | Батлагдсан 884,625.43 сая төгрөгийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар, өссөнөөр жигд биелүүлэн ажиллана. | 97.6% | 100% | Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг жигд хангаан биелүүлэх, нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, иргэнийг нийгмийн даатгалд хамруулах, нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогч, даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн хугацаанд төлүүлэх, авлага барагдуулах шат дараалсан ажлуудыг зохион байгуулан ажиллаж 2026 оны эхний хагас жилп нийгмийн даатгалын санд **394478,8** сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлэхээс **394478,8** сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг **100** хувиар биелүүлсэн.**.** | 100% |
| ***Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| ***Зорилт 3:*** *"Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 3.1. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангаж, байгууллагын цахим | | | 100% | 100% | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангаж, байгууллагын цахим хуудаст болон мэдээллийн самбарт хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан цахим хуудсанд байршуулах 87 нээлттэй мэдээллийг байгууллагын веб сайтад тухай бүрд нь байршуулан, Улирал бүр нээлттэй мэдээллийг байршуулсан байдалд хяналт тавин жиллаж байна. | *10%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуудаст болон мэдээллийн самбарт хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, хяналт тавих; | | | | | | |
| 3.2. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын сан, байгууллагын санхүү үйл ажиллагааны мэдээллийг хугацаанд үнэн зөв, бодитой бүрэн мэдээлж, мэдээлэл байршуултад хяналт тавих; | - | Сар бүрийн хугацаанд байршуулсан мэдээлэл 100 хувь байна. Шилэн дансны хөтлөлтийн тайлан /4/-г байгууллагын цахим хуудаст Улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор мэдээлсэн байна. | 100% | 100% | Газрын мэдээллийн самбарт байршуулах сар бүрийн санхүүгийн мэдээг тогтмол шинэчлэн холбогдох мэргэжилтэнд гарган өгсөн. Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын төсвийн мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй, хуулийн хугацаанд мэдээллэх үүргийн хүрээнд НДСангийн 65 нэр төрлийн, үйл ажиллагааны зардлын 72 нэр төрлийн нийт 137 нэр төрлийн мэдээ мэдээллийг сар бүрийн 8-ны дотор шилэн дансны www.shilendans.gov.mn сайтад байршуулан ажиллахаас 135 мэдээг цаг тухайд нь байршуулсан.<br>Шилэн дансны мэдээллийн санд байгууллагын сангийн мэдээлэл, үйл ажиллагааны мэдээллийг сар бүр үнэн зөв оруулж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж, улирал бүр тайланг Сангийн яам руу хугацаанд нь илгээсэн.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн Шилэн дансны цахим хуудаст тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг мөрдөж ажиллах зөвлөмжид заасны дагуу 2026 оны сарын хөтлөлт, мэдээлэл байршуулсан байдал, холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг бүрэн оруулсан мэдээлэлд хяналт тавьж, мэдээ тайланг НДЕГ-н ДАМГ-т хүргүүлсэн. Программд нийгмийн даатгалын газрын 72, сангийн 65, нийт 137 мэдээлэл оруулсан. | 98% |
| ***Зорилт 3.1:*** *“Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 3.1.1. | Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагад болон газрын үйл ажиллагаа, сангийн зарцуулалтад хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажиллах, | - | Шалгалтын үр дүнг тухай бүрт тооцон газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гарган, актын барагдуулалтын мэдээ, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна. | 100% | 100% | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 02 тоот, Чингэлтэй дүүргийн НДГ-ын даргын 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 01 тоот удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өндөр өртэй аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалтыг нийт 20 аж ахуй нэгж байгууллага хамрагдсанаас: 3 аж ахуй нэгж байгууллагад 43 368 462 төгрөгийн цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос 110 126 972,18 төгрөгийн шимтгэлийг нөхөн төлүүлж шимтгэлийн дүнд 6 902 591 төгрөгийн алданги ногдуулж акт тогтоож ажилласан.17 аж ахуй нэгж байгууллага улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн.Мөн шалгалтаар орсон 20 аж ахуй нэгж байгууллагатай өр төлбөр барагдуулах гэрээ /график/ байгуулсан. Гэрээ байгуулсан 20 аж ахуй нэгж байгууллагын 5,9 тэрбум өр авлагаас 5 аж ахуйн байгууллага нь 923,0 сая төгрөгийн өр төлбөр барагдуулсан. Үүнээс Ганбүрд ХХК нь 100% өр төлбөрийг бүрэн барагдуулсан болно. “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”, нийслэлийн засаг даргын 2013 оны А/1086 дугаартай захирамжаар | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын Edoc-215, Able-107, иргэний өргөдөл-84 системд бүртгэн, холбогдох албан тушаалтанд шилжүүлж, иргэнд хариу өгөх явц болон шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. 2026 оны эхний хагас жилийн байдлаар 406 албан бичиг ирсэнээс Чингэлтэй дүүргийн прокурорын газарт 20 албан хүсэлт нь зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлж хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлүүлэх хүсэлт илгээсэн. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд доорхи арга хэмжээ авч ажилласан. Үүнд:Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан хоцроосон тухай хүсэлтээ өгсөн 20 байгууллага хуулийн этгээдэд нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөх 625 907 162 төгрөгийн цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос 138 455 036,05 төгрөгийн шимтгэлийг нөхөн төлүүлж шимтгэлийн дүнд 21 602 147,45 төгрөгийн алданги ногдуулж зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэргийн материал бүрдүүлж Чингэлтэй дүүргийн прокурорын газарт хүргүүлж ажилласан.Зөрчлийн тухай хуулийн 10.17.4 дахь заалтыг үндэслэн 6,0 сая /зургаан сая/ төгрөгийн торгууль оногдуулж, шийтгэлийн хуудсаар төлүүлэхээр шийдвэрлэсэн торгуулийг 100 хувь барагдуулсан байна. Мөн Чингэлтэй дүүргийн прокурорын газарт 2026 оны эхний хагас жилд Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хийсэн хялбаршуулан шийдвэрлэсэн зөрчлийн хэргийг жагсаалтаар хүргүүлэн явцын хяналт шалгалтанд хамрагдаж зөрчилгүй гэсэн дүгнэлт авсан. Мөн 2026 оны эхний хагас жилийн байдлаар 161 улсын байцаагчийн акт бичигдсэнээс: 10 тэтгэвэр авагчдад 133 994 606,40 төгрөгийн илүү олгосон төлбөр зөрчил буцааж төлүүлэх. 1 тэтгэвэр авагчид 872 000 төгрөгийн тэтгэвэр дутуу олгосон зөрчил арилгах150 аж ахуй нэгж байгууллагад 4,474,045 722,29 төгрөгийн цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос 308,842,542.36 төгрөгийн шимтгэлийг нөхөн төлүүлж шимтгэлийн дүнд 57,506,297.32 төгрөгийн алданги ногдуулсан болно. | |
| 3.1.2. | Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц | - | Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц | | 100% | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 01/336 удирдамжийн дагуу:<br>Чингэлтэй дүүрэгт харьяалагдах нэр бүхий 15 хувийн хэвшлийн их дээд сургууль болон коллежид шалгалт хийхээс 8 байгууллагад шалгалт хийсэн.<br>8 аж ахуй нэгж байгууллага шалгасанаас 43,8 сая төгрөгийн цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос дутуу төлөгдсөн 7,5 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлж, түүнд ногдох 2,8 сая төгрөгийн алданги, Зөрчлийн тухай хуулийн дагуу хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул татгалзах тогтоол үйлдэж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн дагуу улсын байцаагчийн актаар зөрчил арилган ажиллаж байна. | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах; | | хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна. | 100% | | | |
| 3.1.3. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах; | - | Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна. | 100% | 100% | Их, дунд эрсдэл бүхий эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг 58 хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийн 50-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | *100%* |
| 3.1.4. | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нэр бүхий 20 объектод төлөвлөгөөт шалгалт хийх, мэдээ тайланг нэгтгэх; | Батлагдсан төсвийн хүрээнд | Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.. | | 100% | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн “Худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” 05-07/17 дугаартай удирдамжийн дагуу Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа эрсдэлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын судалгааг гаргаж их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нэр бүхий 20 объектод хяналт шалгалт хийх саналыг холбогдох газарт хүргүүлэн батлуулсан боловч Ерөнхий сайдын тушаалаар бүх төлөвлөгөөт хяналт шалгалтыг цуцалсан тул хийгдээгүй.<br>-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” 05-07/28 | *100%* |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 100% | | дугаартай удирдамж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/87 дугаартай тушаалын дагуу Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дах заалт, Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дах заалтын хүрээнд Нийгмийн халамжийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын чанар, үр дүнд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой хяналт шалгалтыг хийсэн.<br>Хяналт шалгалтад хамрагдсан асуудлууд;<br>1.Нийгмийн халамжийн сангийн 2023-2025 оны төсөв, төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт;<br>2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон өндөр насны тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголт;<br>3.Асаргааны тэтгэмжийн тогтоолт, олголт, гүйцэтгэл;<br>4.Протез, ортопед, тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт, олголт, хууль тогтоомжийн хэрэгжилт;<br>5.Ахмадын амралт, сувилал, магадлан итгэмжлэгдсэн рашаан, сувилалын гэрээний хэрэгжилт, үнэ, стандарт;<br>6.Дотоод хяналтын тогтолцоо, эрсдлийн удирдлага.<br>БЗД-н ХХҮГ нь 2025 оны байдлаар өндөр насны тэтгэвэр авагч 998, одой иргэн 9, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 3372, тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртэлх насны хүүхэд 1828, 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг 4 тус тус иргэнийг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулсан байна.<br>ЧД-н ХХҮГ нь 2025 оны байдлаар өндөр насны тэтгэвэр авагч 540, одой иргэн 3, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 1302, тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд 795 нийт 2642 тэтгэвэр авагч, асаргааны тэтгэмж 3580, амьжиргааг дэмжигч мөнгөн тэтгэмж авагч 3223, эх, эцэг олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж 9099, Ахмад настны хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд 8996, Хөгжлийн брэхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээнд 2597, Алдар цолтон ахмад настанд олгох хөнгөлөлтөд 277 иргэнийг хамруулсан байна.<br>Шалгалтад нийт 13,850 иргэн хамрагдсан. Нийгмийн халамжийн сангаас дутуу олгосон тэтгэвэр, тэтгэмжийг нөхөж олгох 19 хүний 8,830,936 төгрөг, нийгмийн халамжийн сангаас илүү олгосон тэтгэвэр, тэтгэмжийг санд буцаан төвлөрүүлэх 11 хүний 3,353,625 төгрөг, нийт 30 хүний 12,277,348 төгрөгийн зөрчлийг илрүүлэн, зөрчлийг арилгах акт хүргүүлж, зөрчлийг арилгасан актын биелэлтийг холбогдох баримтын хамт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газарт 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга нарт албан шаардлага хүргүүлсэн. | |
| 3.1.5. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, | | Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг | | | НДЕГ-ын хяналт шалгалтын улсын байцаагчийн актаар нийт 79 тэтгэвэр авагчийн зөрчлийн актад ажиллагаа хийж 93% хувийн барагдуулалттай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээ, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх, | | барагдуулж, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр днг тооцож, тайланг улирал тутамд гарган Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна. | 100% | 100% | ажиллаж байна. Мөн НШШГЕГ-ын тогтоолын дагуу 89 тэтгэвэр авагчийн тэтгэврийн 50 хувийн суутгалыг хийж сар бүрийн 5-ны дотор хянаж баталгаажуулан, шилжүүлж ажиллаж байна.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газраас хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээ, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажиллаж байна. | *100%* |
| 3.1.6. | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж, заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх; | - | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлэх, төлбөр, зөрлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах, үр дүнг тооцож ажиллах, | 100% | | Дотоодын хяналт, шалгалтын тайланг улирал бүр гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж, заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажиллаж байна. | *100%* |
| ***Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*** | | | | | | | |
| ***Зорилт 4:*** *“Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.1. | Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, шийдвэр, тайлан, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх; | | 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна.<br>Арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн | 100% | 100% | 2026 онд Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, шийдвэр, тайлан, биелэлтийг хэлтэс тус бүрээс нэгтгэн авч нэгтгэн хугацаанд нь хүргүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, биелэлтийг нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 95,4%-тай хэрэгжсэн байна. | *100%* |
| 4.2. | Байгууллага, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, | | Улирал бүрийн 20-ны өдрийн дотор Захиргаа, | | | 2026 оны 06 дугаар сарын 08-ний өдрийн байдлаар тус газарт хандан ирүүлсэн Нийт өргөдөл, гомдол – 358<br>Үүнээс: | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах; | | удирдлагын газарт хүргүүлнэ.<br>-Өргөдөл шийдвэрлэлтийг 100% хугацаанд нь, үнэн зөв, бодит үр дүнтэй шийдвэрлэсэн байна. | 100% | 100% | Нийслэлийн цахим 11-11 төвөөр -108<br>1800-1200 дугаарын оператор 3, өргөдөл<br>Үүнийг төрлөөр нь ангилбал:<br>• Хүсэлт -202<br>• Гомдол – 104<br>• Санал -1<br>Албан хаагчдаас-17 ирсэн байна . Шийдвэрлэлтийн дундаж 7 хоног байна.<br>2026 оны байдлаар ирсэн бичиг-720, явсан бичиг- байна.<br>Ирсэн бичгээс шийдвэрлэгдсэн-715 судалж байгаа-5<br>Үүнийг төрлөөр нь ангилбал:<br>Цаасаар – 123, Цахим программаар–597, албан бичиг ирсэн бөгөөд ажлын 2-3 хоногийн дотор шийдвэрлэн, хариуг хүргүүлэн ажиллаж байна. | |
| 4.3. | Нийгмийн даатгалын газрын ажилтан, албан хаагчдын Нийгмийн даатгалын улсын байцаагч, мэргэшлийн зэргийн нэмэгдэл болон бусад холбогдох судалгааг гаргаж хууль тогтоомжийн дагуу холбогдох баримт бичгийг хүргүүлэх; | | Холбогдох судалгааг гаргаж хугацаанд нь хүргүүлсэн байна. | 100% | 100% | Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх авах шалгалтанд орох 19 албан хаагчийн судалгаа мэдээлэл холбогдох бичиг баримтыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэн ажилласан.<br>Нийгмийн даатгалын мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгуулахаар болзол, шалгуурыг хангасан 9 байцаагчийн судалгааг НДЕГ-т газарт хүргүүлсэн. ГБХНХ-ын Сайдын 2026 оны 04 дүгээр сарын 17 өдрийн А/80 дугаар тушаалаар "Зөвлөх" зэргийг 1, "Итгэмжит зөвлөх" зэргийг 1 улсын байцаагч нийт 2 албан хаагчид олгосон.<br>2 албан хаагчид төрийн захиргааны зэрэг дэвийн нэмэгдлийг олгуулахаар Нийгмийн даатгалын ерөнхий газарт судалгааг хүргүүлсэн.<br>НДЕГ-с ирүүлсэн бүх төрлийн судалгааг хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. | *100%* |
| 4.4. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас батлагдсан "Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн дагуу дунд хугацааны дэд төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах; | Батлагдсан төсвийн хүрээнд | Хэрэгжилтийг 2026 оны 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна. | 100% | 100% | 2026 оны нийгмийн баталгаа хангах хөтөлбөрт 2 зорилт, 4 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан.<br>***Хэрэгжилт:***<br>1. Шалгуур, шаардлага хангасан 2 албан хаагчид мэргэшлийн зэргийн, нэмэгдэл хөлсийг тухай бүр олгуулсан байна. Мөн 2 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдэл олгуулахаар танилцуулга, саналыг 2026 оны 05 дугаар сард НДЕГ-т хүргүүллээ.<br>2. Хөдөлмөрийн хүндэт медаль 5, Сангийн яамны "Санхүү банкны тэргүүний ажилтан" цол тэмдгээр 1, "Жуух бичиг"-ээр 1, шагнал тодорхойлуулахаар Нийгмийн даатгалын ерөнхий газарт судалгаа холбогдох бичиг баримтыг хүргүүлсэн.<br>3. Эхний хагас жилийн байдлаар 52 албан хаагчид хоол, унааны зардалд 252 сая 720 мянган төгрөгийг олгосон байна.<br>4. Ар гэрийн гачигдалтай 5 ажилтанд ажлын 5 хүртэл өдрөөр тооцож цалинтай чөлөө олгосон.<br>ЗГ-ын 2026 оны 119 дүгээр тогтоолын хүрээнд албан хаагч нар зайнаас буюу цахимаар уян хатан цагийн саналыг авч хүсэлтийн дагуу шийдвэрлэн ажилласан. | *100%* |
| 4.5. | Албан хаагчдын ХАСХОМ гаргах ажлыг зохион байгуулж, тайлан | | Авлигын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан | 100% | | Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг зөв мэдүүлэх, төрийн албаны ёс зүйг дээдлэн ажиллах талаар нийт албан хаагчдад тогтмол мэдээлэл зөвлөгөө өгч ажилласны үр дүнд газрын 22 албан хаагч хуулийн хугацаанд ХАСХОМ-ийг | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх; | | байна. | | | шинэчлэн гаргасан бөгөөд https://meduuleg.iaac.mn/ сайтад ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд бүртгэн оруулж, мөн шинээр ажилд томилогдох болон нэгж хооронд шилжин ажиллаж байгаа ТЗ-1-ТЗ-7 зэрэглэлээр ажилладаг 14 албан хаагчдын ХАСУМ-ийг АТГ-т тухай бүр мэдээлж, хариу ирүүлсний дараагаар албан хаагчдыг томилж,тухайн албан хаагчийн шилжин ажилласан албан тушаалд томилсны дараа ХАСХОМ- ийг хуулийн 30 хоногийн хугацаанд шинэчлэн гаргуулж ажилласан.<br>5. Нийт ХАСХОМ-ийг шинэчлэн гаргасан албан хаагчдын мэдээг нэгтгэж хуулийн хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын хуулийн мэргэжилтэнд хүргүүлсэн. | |
| 4.6. | 2026 онд гарсан хууль эрх зүйн зөрчил, шүүхээр шийдвэрлүүлсэн маргаан, хэлэлцэгдэж байгаа хэрэг маргааны судалгааг хүргүүлэх; | | Судалгааг тухай бүр нь хүргүүлсэн байна. | 100% | 100% | Нийслэлийн Чингэлтэй дүүргийн прокурорын газарт Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/62 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Зөрчлийн хэрэг бүртгэлтэд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар”-т заасны дагуу зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан болон эрх бүхий албан тушаалтан нарын судалгааг өгөгдсөн хүснэгтийн дагуу 2026 оны 01 сарын 07-ны өдрийн 01/05 тоот албан бичгийн хавсралтаар хүргүүлсэн.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын Захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтэст Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газрыг төлөөлөн Иргэн, Захиргаа, Эрүүгийн хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон талаарх судалгааг 2026 оны 01 сарын 12-ны өдрийн 01/10 тоот албан бичгийн хавсралтаар хүргүүлж байна.<br>Нийслэлийн прокурорын газарт гуравдагч этгээдээр оролцож шийдвэрлүүлсэн шүүхийн шийдвэрийн биелэлтийн судалгааг 2026 оны 05 сарын 13-ны өдөр тус тус хүргүүлж ажилласан.<br>Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Д.Нямцэрэний ирүүлсэн /20281 дугаар албан бичгийн хариу мэдээллийг 2026 оны 01 сарын 21-ны 01/33 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан.<br>Чингэлтэй дүүргийн цагдаагийн газрын хоёрдугаар хэлтэст 2026 оны 01 сарын 19-ны өдрийн 01/23 тоот албан бичгээр Тус газраас тэтгэвэр авагч Д.Чулуунбаатар, Ц.Хороолсүрэн, Х.Баяртсайхан нар нь хуурамч материал бүрдүүлж, тэтгэвэр тогтоолгосон байж болзошгүй гэх үндэслэлээр шүүхийн шинжээчийн дүгнэлт гаргуулж, хууль тогтоомжийн дагуу шалгуулахаар холбогдох материалуудын хамт дүүргийн Цагдаагийн газрын хоёрдугаар хэлтэст хүргүүлсэн. Дээрх өргөдлийг хэрхэн шийдвэрлэсэн талаар өнөөг хүртэл албан ёсоор хариу ирүүлээгүй байсан тул гомдлын дагуу үүссэн хэрэг бүртгэлийн дугаар болон холбогдох шийдвэрийг тус тус ирүүлж, хамтран ажиллах тухай хүсэлт гаргаж ажилласан. | *100%* |
| 4.7. | Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь хүргүүлж ажиллах; | | -Хугацаанд нь хүргүүлэх,<br>-Баримтын чанар, үзүүлэлт тодорхой байна. | 100% | 100% | Дээд байгууллагаас ирүүлсэн үүрэг даалгаврыг заасан хугацаанд судалгаа, тайлан, үүрэг даалгаврыг биелүүлэн нэгтгэн тухай бүр хүргүүлсэн. | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***Зорилт 4.1:** “Нийгмийн даатгалын байгууллагыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, байцаагч, ажилтныг чадавхжуулах, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургалтыг системтэй, мэргэжлийн түвшинд байнга тасралтгүй явуулах, нөгөө талаар ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын талаарх хууль эрх зүйн мэдлэг олгох хичээл сургалтыг нэгдсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулах”* **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:** | | | | | | | |
| 4.1.1 | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг зохион байгуулах; | | -Авлигаас урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалт зохион байгуулах, -Нийт албан хаагчдыг 100% хамруулсан байна. | | | 2026 оны 03 дугаар сарын 12-ны АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Р.Төрбулаг “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сургалтыг танхимаар зохион байгуулж 27 албан хаагч хамрагдсан. | *100%* |
| 4.1.2 | Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх; | | Сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах, Албан хаагчдыг 100% хамруулсан байна. | 100% | Албан хаагч нар 100% хамрагдсан байна. | 2026 оны 2 дугаар улирлын байдлаар Нийслэлийн төрийн албаны зөвлөл, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн архивын газар, Чингэлтэй дүүргийн Тамгын газруудаас зохион байгуулсан танхимын сургалт 8, гадагшаа чиглэсэн 8-н удаагийн сургалтыг зохион байгуулж албан хаагч нар бүрэн бүрэлдэхүүнээрээ хамрагдсан байна. | *100%* |
| 4.1.3 | Ажил олгогч, даатгуулагч, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах; | | -Даатгуулагчид чиглэсэн сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах, 30-аас доошгүй аж ахуйн нэгжийг хамруулах, Иргэд, даатгуулагчдын 10-иас доошгүй хувийг хамруулсан байна. | Ажил олгогч, иргэд, даатгуулагчид чиглэсэн 52 удаагийн сургалтад 57 аж ахуйн нэгжийн 19653 иргэд, даатгуулагч, ажил олгогчийг хамруулав. | | 1.Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэнтэй холбоотойгоор 2026 оны 03 дугаар сарын 10,25-ны өдрүүдэд 50 ажил олгогчийн нягтлан бодогчдыг хамруулан танхимаар сургалт зохион байгуулж ажил олгогчийг шинэ системд бүртгүүлэх мэдээллийг шинэчлэх, даатгуулагчийн мэдээлэл болон регистрийн дугаарыг үнэн зөв оруулах, даатгуулагчийн төрлийн кодыг зөв сонгох, тайлангаа хуулийн хугацаанд цахимаар илгээхийг анхааруулж зөвлөгөө өгч ажилласан.<br><br>2.Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдөр “Эмэгтэй бизнес эрхлэгчдийн цогц хурдасгуур” хөтөлбөрийн хүрээнд “Туршлага хуваалцах менторинг” сэдэвт сургалт зохион байгууллаа.Сургалтаар Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газрын Хамралт, орлогын хэлтсийн дарга М.Отгонцэцэг, Хайлааст хэлтсийн дарга З.Мөнхнаран нар оролцож, Нийгмийн даатгал ерөнхий хуулийн талаар ажил олгогч, бизнес эрхлэгчдэд мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.<br><br>3. 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК-тай хамтран тус байгууллагын албан хаагчдад нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилт, танилцуулан зөвлөгөө мэдээлэл өгч сургалт зохион байгуулсан.<br><br>***Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар:*** Хувиар хөдөлмөр эрхлэгч иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сайн дурын даатгал, тэтгэвэр тэтгэмжийн даатгал, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ, бусад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, хамрагдалтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээ, ач холбогдлын талаар мэдээлэх, таниулах | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зорилгоор 2026 оны 03 дугаар сарын 11, 17-ны өдрүүдэд Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв, ЧД-ийн 23-р хороотой хамтран сургалт зохион байгууллаа. Сургалтад 80 орчим даатгуулагч хамрагдсан. | |
| ***Зорилт 4.2:*** *“Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, цахим, нэг цэгийн болон явуулын хэлбэрээр нийгмийн даатгалын үйлчилгээг явуулах, олон нийт, харилцагч болон харьяа байгууллагуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.2.1 | Нийгмийн даатгалын байгууллагад хэрэгжүүлж буй ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллах; | - | Шинээр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулна. | 100% | | Тус газар нь ажил үйлчилгээнд гарч байгаа алдаа зөрчил, иргэд даатгуулагчдаас ирж байгаа өргөдөл гомдлыг чирэгдэлгүй, шуурхай шийдвэрлэх, төрийн үйлчилгээний төгөлдөршилийг бий болгох зорилгоор Чанарын менежментийн тогтоолцоо ISO 9001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, ажлын байрны үйлчилгээний орчны стандартыг сайжруулан ханган ажиллаж байна.<br>Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлж ажилласнаар байгууллагын ажлын байрны үйлчилгээний стандартыг сайжруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд даатгуулагчдад чиглэсэн зогсоол, дугааргүй үйлчлэх, цахим үйлчилгээ зэргийг хэвшүүлж, албан хаагчдын хувцаслалт, үйлчилгээний харилцаа хандлагыг мөрдлөг болгон ажиллаж, даатгуулагчдад зориулан мэдээллийн самбарыг шинэчлэн байршуулж ажиллаж байна. | *100%* |
| 4.2.2 | Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах; | - | Дуудлага алдалт 10%-аас хэтрүүлэхгүй ажилласан байна | | | 2026 оны эхний хагас жилийн байдлаар хуваарийн дагуу CallPro утсанд ирсэн.<br>Захиргаа,хяналтын хэлтэс-1012<br>Хамралт, орлогын хэлтэс-7748<br>Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс-10698<br>Санхүү, бүртгэлийн хэлтэс-8677<br>дуудлагыг цаг тухайд нь хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариу тайлбар, мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. Албан хаагчдад дуудлага алдахгүй байх талаар сануулах, мэдээлэл хүргэн, сар сардаа дуудлага хүлээн авах утасны мэдээллийг өөрчлөх CallPro-той холбоотой цагийн тохиргоо, тайлан мэдээг гарган ажиллаж байна. | 100% |
| 4.2.3 | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангах; | - | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгааг “Рийл” улиралд 3-аас доошгүй удаа; “Постер” сард 3-аас доошгүй удаа; “Видео контент” улиралд 1 удаа; Хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан мэдээ мэдээлэл өгөх, сард 2-оос доошгүй удаа; | 100% | 100% | ЗДТГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төвтэй хамтран 34 пост мэдээлэл бэлтгэн дүүргийн цахим хаяг болоод ЧД-ийн 24 хорооны цахим хуудас, группүүд, өөрийн пэйж хуудсандаа түгээн ажилласан. Хандалтын тоо 385200<br>*Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газар* фейсбүүк пэйж хуудсанд:<br>Пост-34<br>Шэйр- 124<br>Нийт хандалт- 385000<br>-*Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газар* фейсбүүк пэйж хуудсыг дагагчийн тоо:16000 | *100%* |

***Зорилт 4.3:*** *“Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эрүүл мэндийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:***

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3.1 | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр ижил мэргэжилтний үзлэг зохион байгуулж, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд тавих дотоодын хяналтыг эрчимжүүлж ажилласан байх; | | Ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулж удирдамж , тайлан | 100% | 100% | “Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлт болон магадлалын үйл ажиллагаанд оролцогч эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар, хариуцлага, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах зорилготой“ Ижил мэргэжилтний үзлэг”-ийг 2026 оны сүүлийн хагас жилд зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгасан болно. | *100%* |
| | | | Дотоод хяналтын төлөвлөгөө, тайлан | | | Цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд сар бүр хяналт тавьж, зөрүүтэй мэдээллийг тухай бүр засаж, зөрчлийг арилгаж ажилласан | *100%* |
| 4.3.2 | Орон нутгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх, бууруулах, эрүүл мэндийн анхан шатны баримт бичгийн эмх цэгцийг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байх; | | Хийсэн судалгаа, дүн шинжилгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх бууруулах чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөө, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан | 100% | 100% | 2026 оны эхний хагас жилийн байдлаар Хөдөлмөрийн чадвар алдалтаа шинээр тогтоолгосон 207, сунгалт хийлгэсэн 560, цуцлагдсан 56, нийт 19 удаа хуралдаж 900 иргэнийг хэлэлцэж, 20 иргэний шилжих хөдөлгөөнийг хийж ажилласан. Мөн нарийн мэргэжлийн эмч болон эрхийн эмч нартай хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх бууруулах талаар байнгын мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна | *80%* |
| | | | Иргэний эрүүл мэндийн анхан шатны баримт бичгийн хадгалалт, эмх цэгцийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан | | | Иргэний эрүүл мэндийн анхан шатны баримт бичиг /амбулаторийн карт, рентгент зураг, CD8 DVD зэрэг/-ийн эмх цэгц, хадгалалт хамгаалалтыг сайжруулах чиглэлээр Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хуралд оролцогч эмч нарт цаг тухай бүрт нь шаардлага тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч өрхийн эмч нарыг чадавхижуулж байна. | |
| 4.3.3 | Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль, тогтоомжийг танилцуулах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр | | Сургалтын хөтөлбөр, оролцогчдын тоо, тайлан | 100% | 100% | Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Дээд газраас зохион байгуулсан сургалтанд ЭММЗ-ийн гишүүдийг цахимаар бүрэн хамруулсан. | *100%* |
| | | | Сургалт, өдөрлөг, цахим сурталчилгааны тоо, мэдээлэл | 100% | 100% | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлт болон магадлалын үйл ажиллагаанд оролцогч эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар, хариуцлага, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах зорилготой“ Ижил | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбогдох эмч, мэргэжилтнүүд болон иргэдэд чиглэсэн сургалт зохион байгуулах; | | авсан иргэдийн тоо, тайлан | | | мэргэжилтний үзлэг”-ийг 2026 оны сүүлийн хагас жилд зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгасан болно. | |
| 4.3.4 | Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөлмжийн хэрэгжилтийг зохион байгуулах; | | Хэрэгжүүлсэн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөмжийн тоо | 2025 онд үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, эрүүл мэндийн магадлалын чиглэлээр 2 судалгаа хийж тайланг Төв зөвлөлд хүргүүлэн ажиллясан | 100%. | Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөлмжийн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. | *90%* |
| ***Зорилт 4.4:*** *“Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.4.1 | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх; | | Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | 100% | 100% | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн "Ажил зохион байгуулах тухай" 01/1500 дугаар албан бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар шимтгэлийн өртэй ажил олгогчийн насжилтын тайлангаас эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, хариуцлагын<br>Хэлбэр ажил олгогчийн мэдээллийг засах ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавих ажлын хүрээнд ажлын олгогчийн бүртгэл идэвхгүй төлөвт шилжсэн тохиолдолд тухай бүрт төлвийг өөрчлөн бүртгэж байна. 2025 оны 12 дугаар сарын 25-ны байдлаар бүртгэлтэй 8657 ажил олгогчийн 4834 ажил олгогчийн мэдээлэл буруу байсныг засах, мэдээллийг шинэчлэх ажлыг зохион байгуулж ажилласнаар 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 318 ажил олгогчийн мэдээллийг цахим системд шинэчлэн бүртгэв.нийт даатгуулагчийн регистрийн дугаар улсын бүртгэлийн мэдээллийн регистрийн дугаартай холбоотой шинэчлэлүүдийг цаг тухай бүрт нь хийж ажиллаж байна. | *100%* |
| | | | Ажил олгогчийн НДШ-ийн тайланд ирүүлэх даатгуулагчийн мэдээллийг бүрэн, | | | Ажил олгогчийн мэдээллийн баазыг засах, шинэчлэх ажлыг тухай бүр хийж гүйцэтгэж ажиллах талаар хэлтсийн дарга болон хариуцсан байцаагч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зөв бүрдүүлсэн байх | | | | |
| | | | Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн гүйцэд шаардаж авсан байх | | | Ажил олгогчийн мэдээллийн баазыг засах, шинэчлэх ажлыг тухай бүр хийж гүйцэтгэж ажиллах талаар хэлтсийн дарга болон хариуцсан байцаагч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. | |
| 4.4.2 | Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх; | | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх | Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан. | | 2026 оны тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан тооцоо хийсэн 5411 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн өдрийн А/199 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журмын дагуу хүлээн авч, хянан цахимаар баталгаажуулан, даатгуулагчийн төрлийг давхардуулан бүртгэхгүй байх талаар нягтлан бодогч нарт заавар зөвлөгөө өгч ажилласан. | *100%* |
| | | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх | | | Сайн дурын даатгуулагчийн мэдээлэл аймаг, дүүрэгтэй давхардсан даатгуулагч эх-53, сайн дурын даатгуулагчтай давхардсан-28 даатгуулагч эхийн бүртгэлийг залруулсан. Давхар ногдуулалт хийсэн 45 даатгуулагч, Ажил олгогчийн цалин, сайн дурын даатгуулагч эх гэрээтэй давхардсан 74 даатгуулагчийн мэдээллийг засварлаж ногдуулсан. Сайн дурын даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой 95 өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. | |
| | | | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байх | | | 2025 оны 12 дугаар сарын 25-ны байдлаар бүртгэлтэй 8657 ажил олгогчийн 4834 ажил олгогчийн мэдээлэл буруу байсныг засах, мэдээллийг шинэчлэх ажлыг зохион байгуулж ажилласнаар 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 318 ажил олгогчийн мэдээллийг цахим системд шинэчлэн бүртгэв. | |
| 4.4.3 | Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах; | | Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах | | | Газарт ашиглагдаж буй компьютер, техник хэрэгслийн өдөр тутмын бэлэн байдлыг ханган ажиллласан бөгөөд тухай бүрт нь сольж хэрэглээний болон шаардлагатай программуудын суулган ажилласан. Нэгжид ашиглагдаж буй https://sicos.ndaatgal.mn программд шинэчлэлт, өөрчлөлтийг цаг тухайд нь хийж байцаагч ажилтнуудын ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажилласан. | 100% |
| | | | МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх | | | Мэдээллийн технологийн төв рүү нийт 3 удаа албан бичиг төлөвлөн. Хариуг авч асуудлыг шийдвэрлэж ажилласан. МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг тухай бүрт нь хүргүүлсэн. https://sicos.ndaatgal.mn эрх шинээр нээх бүх байцаагч, байцаагч нарын эрхийн хуваарьлалт хийсэн. | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 |
| 1 | Үндэсний бичгийн танхимын сургалтанд хамрагдан, бие даан хичээллэж, үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болох; | Танхимын сургалтад 90%-иас дээш ирцтэй хамрагдсан байна. Албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болсон байна. | Үндэсний бичгийн цахим сургалтад хамрагдсан, анхан шатны түвшинтэй байна | Үндэсний бичигт хөрвүүлэх | Монгол бичгийн анхан болон дунд шатны 40 цагийн сургалтад танхимаар хамрагдан унших, бичих, хөрвүүлэх чадвараа сайжруулж, мэдлэгээ нэмэгдүүлж батламж авсан. Архивын Ерөнхий газраас зохион байгуулсан албан хэрэг хөтлөлтийн Эдок систем шинэчлэхтэй холбоотой сургалтанд газрын албан хаагч нарыг хамруулан ажилласан. | *100%* |
| 2 | Нийгмийн даатгалын байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнд хамрагдах; | Сургалт, зөвлөгөөнд бүрэн хамрагдсан байна. | Удирдах ажилтны сургалт-зөвлөгөөнд 2 удаа хамрагдсан. | Зохион байгуулагдсан хугацаанд | Нийгмийн даатгалын байгууллагын удирдах ажилтны сургалт зөвлөгөөнд 1 удаа хамрагдсан. | *100%* |
| 3 | Манлайллын ур чадварын талаарх сургалтад хамрагдах; | Удирдлагын манлайллын ур чадварын өнөөгийн түвшингээ тодорхойлж, хувь хүний манлайлах ур чадвараа ахиулах сургалтад 1-ээс доошгүй удаа хамрагдана. | - | Тухай бүр | Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчийн ёс зүй, хууль тогтоомжийг мөрдөж нээлттэй, ил тод, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, байгууллагын соёлыг сайжруулахад санал санаачилга гаргах, Нийгмийн даатгалын аливаа мэдээлэл, судалгааг, давхардуулахгүй байхад анхаарч, бүх шатанд манлайлал үзүүлж ажиллах зорилгоор сургалтад хамрагдав. Уг сургалтаар удирдлагын ур чадвар, эрх зүйн ойлголт, гүйцэтгэх удирдлага, хариуцлагатай ажилтан, хувь хүний талаар ойлголтоо баяжуулж, ур чадвараа ахиулах боломжийг олголоо. | *100%* |
| 4 | Компанийн засаглалын сургалтад хамрагдах; | Удирдлагын ур чадвар, эрх зүйн ойлголт, гүйцэтгэх удирдлага, хариуцлагатай ажилтан, хувь хүний талаар мэдээлэлтэй болсон байна. | - | Тухай бүр | | *100%* |

.---оОо---